



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/32

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны III/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын тэмцээн уралдаанд оролцогчдод гардуулах медалийн эх загвар, дурсгалын тэмдэгийн их загвар, өргөмжлөлийн хавтас, медаль бэлтгэх ажлын гүйцэтгэгчээр “ИМААР ТРЕЙД” ХХК-ийг сонгож, 9,202,500 (есөн сая хоёр зуун хоёр мянга таван зуу) төгрөгөөр гэрээ байгуулан, хяналт тавьж, хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

2. “Алтаргана 2024” наадмын тэмцээн уралдааны медалийн эх загвар, дурсгалын тэмдэгийн их загвар, өргөмжлөлийн хавтас, медаль бэлтгэх ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “ИМААР ТРЕЙД” ХХК-ийн захирал (П.Баярхүү)-д даалгасугай.

3. Санхүүжилтийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010579

Аймгийн Засаг даргын 2024 оны
06 дүгээр сарын 17-ны өдрийн 14/14 дугаар



“Алтаргана 2024” олон улсын XV их наадамд медаль, медалион зоосны эх бэлтгэл
медаль хэвлэл, өргөмжлөлийн хавтасны зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
1	Медаль	407 ш	15,500	6,308,500
2	Эх бэлтгэл	-	310,000	310,000
3	Өргөмжлөлийн хавтас	304 ш	8,500	2,584,000
захирамжийн хавсралт			Нийт үнэ	9,202,500